

Шувууны томуугийн А/Н5N1/ вирүсийн халдвараас сэргийлэх арга хэмжээний зөвлөмж

БГХӨС Төвтэй аймгуудаас зохион байгуулан явуулах ажлууд.

Үндэслэл:

2003 оноос өнөөдрийг хүртэлх хугацаанд БНХАУ, Камбож, Лаос, Вьетнам, Тайланд, Малайз зэрэг Зүүн Өмнөд Ази, Европ, Евро-Азийн 45 оронд зэрлэг болон гэрийн тэжээвэр шувуудын өвчлөл, 15 оронд нийт 498 хүн өвчилж, 294 нь нас барсан.

2010 он гарсаар шувууны томуугийн хүний өвчлөл Камбож, Египед, Индонез, Вьетнам зэрэг 4 улсад 30 тохиолдол бүртгэгдэж, нас баралт 40% (12)-тай байна.

Хэдийгээр манай оронд шувууны томуугийн хүний өвчлөл бүртгэгдээгүй ч байгалийн голомт илэрсээр байгаа тул шувууны томуугийн А/Н5N1/ вирүсийн халдвараас хүн амыг сэргийлэх, аймаг, орон нутгийн бэлэн байдлыг ханган дараах ажлуудыг зохион байгуулан явуулах шаардлагатай байна. Үүнд:

Аймгийн ЭМГ-аас

1. Шувууны томуугийн А/Н5N1/ вирүсийн халдварын дэгдэлтээс сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулан ажиллах

2. Эмч, эмнэлгийн ажилтан нарыг шувууны томуугийн А/Н5N1/ вирүсийн халдвараас сэргийлэх талаар сургалтад хамруулах

3. “Шувууны томуугийн хүний өвчний сэжигтэй тохиолдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ” сэдэвт үзүүлэх сургууль зохион байгуулж эмч, эмнэлгийн ажилтан нарыг дадлагажуулах, бэлэн байдлыг хангах

4. ЭМС-ын 2004 оны 45 дугаар тушаалын дагуу бэлэн байдалд шаардлагатай эд зүйлсийн /хамгаалах хувцас, эм тариа, оношлуур, урвалж, шил сав, шинжилгээний багаж хэрэгсэл, аппарат тоног төхөөрөмж, халдваргүйтгэлийн бодис, маска, бээлий, гар ариутгах, ам зайлах бодис гэх мэт/ тооцоо гаргаж, нөөц бүрдүүлэх

5. Хүн амд шувууны томуу өвчнөөс сэргийлэх арга хэмжээний талаар мэдээлэл, сурталчилгааг өргөн хүрээтэй зохион байгуулж, зөвлөмж сэрэмжлүүлэг хүргүүлэх

6. Шувууны томуугийн хүний өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн үед мэдээ, мэдээллийн урсгалын дагуу холбогдох газруудад яаралтай мэдээлэн, хариу арга хэмжээ авч ажиллах

БГХӨС Төвөөс дараах ажлуудыг зохион байгуулан явуулах:

1. Шувууны томуугийн А/Н5N1/ вирүсийн халдварын дэгдэлтээс сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулан ажиллах

2. ЭМС-ын 2004 оны 45 дугаар тушаалын дагуу шаардлагатай эд зүйлсийн /хамгаалах хувцас, эм тариа, оношлуур, урвалж, шил сав, шинжилгээний багаж хэрэгсэл, аппарат тоног төхөөрөмж, халдваргүйтгэлийн бодис, маска, бээлий, гар ариутгах, ам зайлах бодис гэх мэт/ тооцоо гаргаж, нөөц бүрдүүлж бэлэн байдлыг хангах

3. Аймаг, сум орон нутгийн Засаг захиргаа, Мэргэжлийн хяналт, Мал эмнэлэг болон бусад холбогдох газруудтай хамтран:

а/. Шувууны аж ахуй эрхлэгч болон шувууны мах, өндөг, түүхий эдийн худалдаа хийдэг байгууллага, айл өрх, иргэдийн судалгаа гаргаж, халдварт өртөх эрсдэлт бүлгийн хүн амыг тогтоох, судалгаатай болох

б/. Шувууны аж ахуй эрхлэгч байгууллага, айл өрх, иргэдийн тэжээвэр шувууны тоог гаргаж, томуугийн эсрэг дархлаажуулалтад хяналт тавин ажиллах

в/. Аймаг, орон нутгийн Засаг захиргаа, Онцгой байдал, Мэргэжлийн хяналт, Хүн, мал эмнэлэг, шувууны аж ахуй эрхлэгч байгууллагуудын ажилтан, эмч, мэргэжилтэн нарыг шувууны томуугийн А/Н5N1/ вирүсийн халдварын талаарх сургалтад хамруулах, үзүүлэх сургууль зохион байгуулан явуулж, дадлагажуулах

г/. Шувууны аж ахуй эрхлэгч байгууллагын бэлэн байдалд шаардлагатай эд зүйлсийн тооцоо гаргаж, нөөц бүрдүүлэхэд зөвлөн туслах

4. Хүн ам, шувууны аж ахуйд ажиллагсад болон шувуу тэжээдэг иргэдэд сургалт, сурталчилгаа хийх

5. Шувууны томуугийн хүний болон шувууны өвчлөлийн сэжигтэй тохиолдол илэрсэн үед мэдээ, мэдээллийн журмын дагуу холбогдох газруудад яаралтай мэдээлэн, хариу арга хэмжээ авч ажиллах

6. Хүн ам болон шувууд зусдаг нуур орчимд тархварзүйн тандалт судалгааны ажлыг зохион байгуулан явуулж:

а/. Хүн амаас асуумж судалгаа авч, шувууны томуу өвчний талаарх мэдлэг, дадал, хандлагад үнэлэлт өгөх, халдварт өртөх эрсдэл, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлон урьдчилан сэргийлэх ажлын чиглэл гаргах

б/. Нуур орчмын зэрлэг шувуудад ажиглалт, судалгаа хийх


в/. Шувуу үхсэн болон өвчилсөн тохиолдолд мал эмнэлгийн байгууллагын зөвлөмжийн дагуу ажиллах

г/. Нуур, цөөрөм орчмын хүн амд шувууны томуугийн халдвараас сэргийлэх талаар сурталчилгаа хийж /хувийн ариун цэвэр тогтмол сахих, үхсэн болон өвчилсөн шувуутай харьцахгүй байх, мэргэжлийн байгууллагад мэдэгдэх, шувуу үхсэн гол, нуурын усыг ундандаа хэрэглэхгүй байх, малаа оруулахгүй байх, өвчилсөн, үхсэн шувуутай харьцсаны дараа халуурсан, ханиалгасан үед эмч дуудаж үзүүлэх, эмчийн хяналтанд орох гэх мэт/

ТАНИЛЦУУЛГА

Шувууны томуугийн хүний өвчлөлийн олон улсын төлөв байдал (2003-2010 он)

ДЭМБ-ын мэдээлснээр 2003-2010 онд шувууны томуугийн хүний өвчлөл 15 улсад нийт 498 тохиолдол бүртгэгдэж нас баралт 59% (294)-тай байна.



2010 он гарсаар шувууны томуугийн хүний өвчлөл 5 сарын 6-ны байдлаар Камбож, Египет, Индонез, Вьетнам зэрэг 4 улсад 30 тохиолдол бүртгэгдэж, нас баралт 40% (12)-тай байна (хүснэгт1, дүрслэл 1).


Шувууны томуугийн хүний өвчлөл (2010-5-6 байдлаар)

Хүснэгт 1

Улс	Өвчлөл	Нас баралт
Египед	19	7
Вьетнам	7	2
Индонез	3	2
Камбож	1	1
Нийт	30	12

Шувууны томуугийн хүний өвчлөл (2010-5-6 байдлаар)

Дүрслэл 1



Шувууны томуугийн хүний өвчлөлийн 36,7% нь II, 30% нь I, 26,7% нь III, 6,7% нь IV саруудад тус тус бүртгэгдсэн байна (дүрслэл 2).

*Шувууны томуугийн хүний өвчлөл сараар (2010-5-6 байдлаар)
(дүрслэл 2)*

